

Солонгос үндэсний дуулалт жүжиг “Пансури” дахь авиа дуурайх, дүрслэх үг

Рюү Сүёл

Ханьян их сургуулийн солонгос хэлний тэнхмийн профессор

1. Шинэ авиа дуурайх, дүрслэх үг бий болох нь

‘부끄부끄(bukkeubukkeu)’, ‘쓰담쓰담(sseudamsseudam)’.

Ухаалаг утасны мессэжний дэлгэцэнд урьд нь байдаггүй байсан авиа дуурайх, дүрслэх үг олонтаа харагдах болжээ. “Ичингүйрч буй байдал”, “гараар илэх буюу тайтгаруулах байдал” зэргийг дуурайсан үгс юм. “Маш их ичиж байгаа байдал”-ыг илэрхийлсэн ‘쭈스쭈스(сүгс сүгс)’, “шуналтайгаар идэх байдал”-ыг илэрхийлсэн ‘치떡치떡(чөмөг чөмөг)’ гэх үг ч бий. Солонгос хэлний дүрэмд тохирохгүй шинээр бүтсэн үг ч бас, сэтгэл хөдлөлийн тэмдэг(emoticon)-ийг орлох үг болоход сайхан тохирох юм. Энэ ч бас авиа дуурайх, дүрслэх үг мөн үү гэх асуултад дуртайяа тийм гэж хариулахад хэцүү. Гэвч дүр зураг болон үйл хөдлөлийг нүдэнд харагдахуйц дүрслэх авиа дуурайх, дүрслэх үгийн үүрэг гүйцэтгэж буй талаас нь үгүйсгэхэд ч хэцүү. Энэ нь авиа дуурайх, дүрслэх үг бий болох үзэгдэл юм.

Тэмдэгтийг дуудлага, утга хоёрын нэгдэл гэж үзэх нь хэлшинжлэлийн нэгэнт тодорхой болсон онол юм. Тэр нэгдэл нь бие даасан гэдэг үзэл бас өргөн дэлгэрсэн ердийн ойлголт юм. Гэвч авиа дуурайх, дүрслэх үг нь үүнээс тусдаа гэж үзэх нь бий. Авиа дуурайх, дүрслэх үг нь физикийн, оюун ухааны дүр байдлыг сонсох, харах мэдэрхүйгээр дуурайсан хэлний тэмдэг юм. Өөрөөр хэлвэл дуу авиа, хэлбэрийг дуурайсан үг юм. Тиймээс авиа дуурайх, дүрслэх үг нь тэмдэглэгээ ба утга хоорондын уян хатан чанарыг харуулж буй бодит жишээ юм.

Солонгосын уран зохиолын олон төрөл дундаас авиа дуурайх, дүрслэх үг нь хамгийн их орж, давтагдсан зохиол бол мэдээж үндэсний дуулалт жүжиг “пансури” юм. “Пансури” нь ерөнхийдөө “сонсгох” дуу авиагаар дамжуулан “харуулах” үүрэгтэй жүжигчилсэн зохиол учраас юм. Тиймээс уг өгүүлэлд пансуригийн зохиолд авиа дуурайх, дүрслэх үг нь ямар үүрэгтэйг судалж үзэх болно.

2. Авиа дуурайх, дүрслэх үгийн дүрслэлийн үүрэг

Үндэсний дуулалт жүжиг “пансури” нь үзэгдэл тус бүрийг бүрэн дүүрэн дүрслэх гэсэн урлагийн чиг хандлагыг харуулж байдаг. Төрөл бүрийн өнгө аяс илэрхийлэх үг болон мэдрэмж илэрхийлэх үг ихээр илэрдэгт анхаарал хандуулбал хялбар ойлгоно. Ялангуяа “пансури”-ийн шинэчлэн найруулагдсан зохиолын найруулгаас

러거든 조르지 말고 잡아가거라. 내가 무슨 죄 있느냐?

Жу Сан Хёны зохиосон <Чүнхянга>-гийн дууны үг юм. Бён даргын төрсөн өдрийн өмнөх өдөр Чүнхяний ээж нь И Дурёнтай хамт шоронд хоригдсон Чүнхянтай уулзахаар явж буй хэсэг юм. Үхэлтэй тулгарсан Чүнхян болон охиныхоо амь насанд санаа зовж буй эхийн сэтгэлээс үзэхэд, энэ хэсэг нь дэндүү гунигтай үзэгдэл бөгөөд энэ гунигт үзэгдлийн шинж чанар Жинянжугийн хэмнэлд илүү хүчтэй илэрнэ. Энэ үзэгдэлийг дүрсэлсэн үгэнд ч авиа дуурайх, дүрслэх үг багагүй илрэх бөгөөд тухайн нөхцөл байдлын гунигт шинж чанарыг нэмэгдүүлж байна. Энэ нь авиа дуурайх, дүрслэх үг нь ерөнхийдөө ноцтой, түгшүүртэй үзэгдлээс илүү сул чөлөөтэй үзэгдэлд сайн тохирох утгын онцлог шинжтэй зөрчилдөх нь ч бий. Гэхдээ бага боловч энэ үзэгдэлд авиа дуурайх, дүрслэх үг нь эсрэгээрээ ноцтой, түгшүүртэй байдлыг илүү хүчтэй болгох чиглэлээр хэрэглэсэн байна гэж үзэж болно.

Үүнээс үзвэл авиа дуурайх, дүрслэх үг нь өөрөө ямар нэгэн онцгой уур амьсгалыг бүрдүүлэхээс илүү объектив нөхцөл байдлын харуулж буй уур амьсгалыг хүчтэй болгох, өргөжүүлэхэд туслах үүргийг гүйцэтгэж байгаа нь харагдаж байна. Мөн тэр үүрэг нь авиа дуурайх, дүрслэх үгийн ерөнхий хязгаарыг давж, хэрэглэгдэж буй онцлогийг агуулж байна. Энэ үед түүний үүрэг нь харах эсвэл сонсох мэдэрхүйн сэтгэл хөдлөлийг бий болгож, заах эцсийн үр дүнд хүрдэг. Энэ нь авиа дуурайх, дүрслэх үгийн дүрслэх үүрэгт хамаарна гэж хэлж болно.

Авиа дуурайх, дүрслэх үг нь ерөнхийдөө дуу авиа ба хэлбэрийг тэр чигээр нь дуурайсан үг учраас нарийн дүрслэлд анхаарал хандуулахад шууд үр дүнтэй. Ялангуяа шүлэгт авиа дуурайх, дүрслэх үг их хэрэглэх тусам хэмнэлийн үр ашиг төдийгүй түүний илэрхийллийн мөн чанар хүртэл түүнтэй жишигдэж өсдөг. Авиа дуурайх, дүрслэх үгийг чөлөөтэй хэрэглэхийг нэг талаар хориглодог ханз шүлэгт ч бас бодитоор дуурайх үед зайлшгүй авиа дуурайх, дүрслэх үгийг заавал хэрэглэх тохиолдол байдаг. Энэ нь бүгд авиа дуурайх, дүрслэх үгийн агуулж байдаг илэрхийллийн үүргийг товч боловч харуулж байна.

И Дурён нь Чүнхяний өрөөнд харсан зургуудыг дуурайсан хэсэгт ч авиа дуурайх, дүрслэх үг гардаг. Тиймээс тэр зургууд яг амьд хөдлөж буй мэт эндүүрэх хэмжээний бодит байдлыг мэдрүүлж өгдөг. Дэндүү ганихарсан, ганцаардсан үзэгдлийн нэг хүний ганцаараа дуулах <Чүнхянга>-ын 'Манбүса' дуу ч бас адил юм. И Дурён нь “ухас хийн гүйн орж ирээд миний бүсэлхийнээс тэвэрсэн” өнгөрснийг эргэн дурсаж, өвлийн улирал 뚜루뚜루뚜루 기록(дүрүүрүүрү гирүг) дуугаран явах зэрлэг галууны дуу” ч бас хайртай хүнээ бодож буй энэ үед ч бас авиа дуурайх, дүрслэх үг нь тод дүрслэлийг илэрхийлэхэд шийдвэрлэх үүрэгтэй оролцож байна.

Пансури нь хэрмэл жүжигчин сонсогч, үзэгчидтэй шууд уулзаж, үгээр яриаг дамжуулж жүжиглэдэг урлаг юм. Ийм төрлийн онцлогоос харахад авиа дуурайх, дүрслэх үгийн хэрэглээ нь эцэстээ сонсогч, үзэгчдийн сэтгэлийн уянгыг илэрхийлэх

үүргийг гүйцэтгэдэг. Энэ тал нь <Жусон чангыгса>-д уламжлагдаж ирсэн өнгөрсөн үеийн алдартай дуучны дуунуудаар дамжуулан хангалттай мэдэж болно.

Алдарт дуучин И Налчи нь <Чүнхянга> дуулж байх үед бүрээний дуу болон хонхны дуу гаргавал яг бодит юм шиг сонсогдож, шувууны дуу дуулах үед гаргах шувууны дуунд бодитоор адил төрлийн шувуу нисэж ирсэн гэдэг. Ким Чан Руг мөн хар хэрээний дууг гаргавал ил тэнгэрээс бууж ирэх мэт санагддаг гэж гарсан байна. Эдгээр сурвалж бичигт авиа дуурайх үгийг бодит байдалд хэчнээн ойртуулж дуудаж байгаа вэ гэдэг нь пансуригийн жүжигчдийн ур чадвараар онцлогдож байсныг баталж байна. Мэдээж тэр үр дүн нь сонсогч, үзэгчдийн сэтгэл хөдлөлөөр илрэх юм.

Гэхдээ авиа дуурайх, дүрслэх үг нь дүрслэх илэрхийллийн үр дүнг нэмэгдүүлж болох хэлний онцлог гэж үзсэн ч зорилгогүй хэрэглэгдэхгүй гэдгийг мэдүүлэх нэг сайн жишээ юм. Ким Чанобийн тухай яриа юм. Нэгэн удаа алдарт дуучин Жөн Чаноб нэгэн газар <Хынбүга> -ийн “хувилгаан лам бууж ирэхэд урт ханцуй нь салхинд дэрвэн” гэсэн байна. Үүнд Ким Чаноб шүүмжлэн “хувилгаан ламын ханцуй нь салхинд дэрвэн” гэх нь хүчтэй салхи ч салхилаагүй, хүчтэй онгод орж хөдөлж байгаа ч биш байхад ханцуй нь тэгж дэрвэх гэж байх уу. Дулаахан хаврын салхинд хувилгаан ламын “урт ханцуй салхинд хийсэн” гэх нь бодит байдалд тохирно.” Гэж үзжээ. Жөн овогт ч бас түүний шүүмжийг хүлээн зөвшөөрсөн гэнэ.

Ая, зохиолд ч энэ талд нь тохирох дүрслэлийг илэрхийлдэг нь ч пансуригийн үндсэн чиглэл бөгөөд авиа дуурайх, дүрслэх үгийн илэрхийллийн үр дүн ч бас энэ талыг нь хасаж болшгүй зүйл гэдгийг ойлгуулж өгнө. Сонсогч, үзэгчдийн сэтгэлийн хөдлөлийн хэмжээ пансуригийн жүжигчний ур чадварыг баримжаалах гол шалгуур гэдгийг бүгд мэднэ. Авиа дуурайх, дүрслэх үгийг бодитоор, нөхцөл байдалд тохируулж хэрэглэх үзэгдлийг дүрслэх нь ур чадваруудын нэгээхэн хэсэг гэдгийг мэдэж болно.

3. Авиа дуурайх, дүрслэх үгийн хөгжөөх үүрэг

Пансуринд авиа дуурайх, дүрслэх үгийн үүрэг нь дүрслэлийг заах илэрхийллийн үр ашгаар зогсохгүй. Авиа дуурайх, дүрслэх үгийн бий болгох шаардлагаар төстэй авиа давтагдаж байгаагаас мэдэж болох шиг, авиа дуурайх, дүрслэх үг нь өөрөө давтамжтай хэмнэлт утгыг агуулж байдаг. Энэ талаасаа авиа дуурайх, дүрслэх үг нь мэдээллээр хангах гэсэн хэлний нэг үүрэгтэй холбоогүй бөгөөд, сэтгэлийн хөдөлгөөн болон хөгжөөх үүргийг тэмдэглэсэн үр дүн юм. Ялангуяа анхаарах зүйл нь авиа дуурайх, дүрслэх үгийн хөгжөөх үр ашиг нь ерөнхийдөө өгүүлбэр зүй, утга зүйн үүргийг дэлгэрүүлэхээс эхэлсэн чиглэл нь хүчтэй юм. Доор иш татсан зохиол нь авиа дуурайх, дүрслэх үгийн энэ онцлог шинжийг тохиромжтойгоор харуулж байна.

“아이고 이것이 웬 말이냐? 워따 동네 사람들, 우리 마누라가 죽었소? 허허허어(heoheoheo) 참으로 죽었소?”

아이고 마누라, 죽을 줄 알았으면 약 지러 가지 말고 머리맡에 앉았다 극락세계로 가라고 염불이나 해 줄 것을. 약능활인이요, 병불능살인일터니 약이 모두 원수로다.” 약그릇을 번뜻 들어 방바닥에 부딪치고, 썩다 꺼꾸러져 데그르르르르(degeureureureu) 굴러보고, 가슴을 쿵쿵(kwangkwang) 치고 머리도 찌걱찌걱(jjigeokjjigeok) 두 발을 뚱뚱뚱뚱(dungdungdungdung), 여광여취(yeogwangnyeochwi) 실성발광(silseongbalgwang) 남지서지(namjiseoji)를 가르쳐“, 아이고 마누라, 마오. 죽지 마오. 평생의 정한 뜻을 사생동거 보잖더니 염라국이 어디라고 날 버리고 가라시오? 아이고, 마누라, 마누라, 마누라, 마누라, 이게 웬일이요? 인제 가면 언제 와요?” 목제비질을 덜컹덜컹 이리저리 헤매이며“ 아이고 마누라, 아이고 이를 어쩔거나.”

Хан Эсүний зохиол <Шимчонга>-ийн нэг хэсэг юм. Эхнэрээ алдсан Шим бунса(хараагүй) нь туйлын баатарлаг сэтгэлээ нээн ярьж буй энэ хэсэг нь Шим Бунсагийн өөрийн дуу юм. Энэ дуунд анхаарал татаж байгаа зүйл нь Шим Бунса гэдэг хүний яриа болон өгүүлэгчийн яриа нь өнгө аяс талаас их ялгааг харуулж байгаа юм. Шим Бунса нь нөхцөл байдлын ноцтой шинж чанарт тохирохгүй “эм гэдэг зүйл хүнийг эмчилдэг, өвчин гэдэг зүйл хүнийг алдаггүй” гэсэн үгийг хэлээд санаа алдаж байна. Гэвч өгүүлэгчийн дуу хоолой нь уг хүний байр суурьтай хамаагүй шоглосон ярианы өнгө аясаар үргэлжилнэ. Энд тэр шоглосон хандлагыг хангалттай хүчтэй болгодог хэлний хэрэглүүр бол авиа дуурайх, дүрслэх үг юм. Энэ нь авиа дуурайх, дүрслэх үг нь ерөнхийдөө үгүйсгэсэн далд гүн утгыг агуулж дүрслэхэд хэрэглэдэг илэрхийлэл бөгөөд, нэгэн цаг үед үйлдэл ба хандлагыг хоосон дэврээх үүрэгтэй холбоотой. Ялангуяа энэ дуунд “ёгуанг ёчи”, “шилсөн балгуанг”, “намжи сөжи”, “ири жөри” зэрэг авиа дуурайх, дүрслэх үг биш үгс хүртэл төстэй авиа давталтаар дамжуулан авиа дуурайх, дүрслэх үгтэй адил үүргийг гүйцэтгэснээр хошин уур амьсгалыг илэрхийлдэг.

Нөгөө талаар хүндэтгэлийн арга хэрэглэх ёстой хүнд авиа дуурайх, дүрслэх үгийг хэрэглэхэд хэцүү гэсэн ерөнхий онцлог шинж нь хошин уур амьсгалыг шинээр бий болгоё гэвэл авиа дуурайх, дүрслэх үг нь нэлээд нийгмийн дээд гаралтай хүмүүсийг егөөдсөн үгээр сануулах юм уу егөөдөх үүргээр хэрэглэх нь ч бий. Энэ талаасаа Бён түшмэл болон Бэндогийн ээж, Нулбү, Жужу зэрэг голдуу үзэгчдийн байр суурьнаас хүлээн зөвшөөрөхөд хэцүү хүмүүсийн үйлдлийг дүрслэх хэсэгт илэрдэг онцлог шинж юм. Гэвч авиа дуурайх, дүрслэх үгийн хөгжөөх үүрэг нь нийтдээ баяр баясгалантай, хөгжилтэй мэдрэмжийг илэрхийлэх үзэгдэлд хамгийн тодорхой илэрдэг. Баяр баясгалан ба хөгжилтэй мэдрэмж нь авиа дуурайх, дүрслэх үг нь дуу авиа ба хэлбэрийг дуурайсан үг гэсэн онцлог шинжээс хамааран аяндаа дүрслэгддэг мэдрэмж юм.

[중중모리장단] “광한루 머지 앓고, 녹음은 우거지고 방초는 푸르러, 앞내 버들은 청포장 두르고 뒷내 버들은 유록장 둘러, 한 가지는 찢어지고 또 한 가지는 늘어져, 춘비춘홍을 못 이기어서 흔들흔들 (heundeulheundeul) 너울거리고 춤을 출 제, 외씨 같은 너 발 맵시는 백운간의 해뜰(haetteuk), 홍상 자락은 펼

링(peolleong), 선웃임 뽕긋(ppanggeut), 입속은 해떡(haetteuk), 도련님이 너를 보시고 불렀지, 내가 무슨 말을 하였다는 말이야? 잔말 말고 건너가자.”

Чу Санхён зохиосон <Чүнхянга>-аас авсан дууны үг юм. Энэ дууны үг нь Чүнхян дээр очиж И Дурён зарлиг шалтгаан нь Чүнхяний өөрийнх нь буруу байсан талаар хэлдэг үг юм. Эндээс ‘흔들흔들-санжигнах’-аас гадна бусад, өөрөөр хэлбэл, ‘해떡(haetteuk)’, ‘펼링(peolleong)’, ‘뽕긋(ppanggeut)’, ‘해떡(haetteuk)’ нь хэдийгээр төстэй авиа давтагдахаас болж бүтээгдсэн авиа дууриах, дүрслэх үг биш боловч ч ‘발 맵시(хөлний хэлбэр)’, ‘홍상 자락(улаан дээлний хормой)’, ‘선웃음(хуурамч инээмсэглэл)’, ‘입속(аман дотор)’-той тус тусд таарангаа жавхаалаг Чүнхянын дүр төрхийг тод тодорхой илэрхийлэхэд дутах зүйл байхгүй. Наад зах нь боолийн байр сууринд Чүнхяны дүр төрх нь сэтгэл татам байх тусам И Дурён нь Чүнхяныг дуудсан нь илүү учир шалтгаантай гэж дүгнэж болно. Эндээс үл тоож болохгүй зүйл дуу шуугианаас болж бий болдог хэмнэл юм. Өгүүлэгч нь ‘해떡(haetteuk)’, ‘펼링(peolleong)’, ‘뽕긋(ppanggeut)’, ‘해떡(haetteuk)’ –ийг нүүр хувирлын жүжигтэй хамт ярьж буй газар байвал, тэр хэмнэлээс гардаг зугаа цэнгэл нь ямар байх вэ гэдгийг хүн бүр өөр өөрөөр төсөөлөөрэй. Энд ‘Жүнжүнмури ая’ нийлсэн учраас тэр үр дүнг заавал тайлбарлах шаардлагагүй.

4.Дүгнэлт

Дээрх судалгаан нь Пансурид авиа дуурайх, дүрслэх үг нь олонтоо хэрэглэгддэг нь дүрсийг хамгийн бодитоор илэрхийлэх гэсэн санаа юм уу, сонсох мэдрэхүйн дуу чимээний хэмнэлт хөдөлгөөний зугаа цэнгэл идэвхжүүлэх гэсэн санаа зорилгоос гарсан гэж хэлж болно. Түгшүүртэй ноцтой үзэгдэл буюу хошин уур амьсгалтай баяр баясгалантай үзэгдэлд, авиа дууриах, дүрслэх үг нь тус тусдаа тэр үзэгдлийн ерөнхий уур амьсгалд тохирч зохицсон юм.

Авиа дууриах, дүрслэх хэл нь дуу буюу дүрслэлийг тэр хэвээр нь дуурайсан үг гэсэн зүйл нь тэр хэмжээгээр объектийн бодит байдалыг яг адилхан илэрхийлэх гэсэн зорилгыг тэр чигээр нь агуулж байгааг илэрхийлдэг. Тэгээд Пансурид авиа дууриах, дүрслэх үг нь олон хэрэглэгдэж байгаа зүйл нь пансуригийн хэл бас тийм санаа зорилгыг тодорхой харуулж байна гэсэн утгатай.

Пансури нь бодитой зүйлийг авианы хэлээр илэрхийлэх гэж байгаа жүжигчилсэн хүсэлтийг ‘Биеийн хөдөлгөөн’-өөр тайлбарладаг. Шин Жэ Хюу-гийн <Гуйндэга>-аар дамжуулан “Биеийн хөдөлгөөн гэдэг нь гоё сайхан төрх бөгөөд богино хугацаанд олон янзаар өөрчлөгдөх, бурхан болоод чөтгөр болоод түмэн янзаар өөрчлөгдөж, сууж байгаа зугаа цэнгэлд дуртай эрэлхэг зоригтой хүн, юм үзэж байгаа хөгшин залуу эрэгтэй эмэгтэй хүмүүсийг уйлуулж инээлгэдэг ийм гоё ийм сайхан нь ямар хэцүү байгаа...” гэж хэлэнгээ ‘Биеийн хөдөлгөөн’-ийг өгүүлэгчийн чухал ур чадвар гэж тогтоосон. Эндээс батлагдсан шиг биеийн

хөдөлгөөн нь дуучны жүжиглэлтийн талаар сонсогч, үзэгчдийн хариу үйлдэл юмуу сэтгэлийн хөдөлгөөний талаас ямар ч элементтэй харьцуулахад маш чухал элемент юм. Авиа дууриах, дүрслэх үг нь энэ биеийн хөдөлгөөний төлөө шаардагдаж байгаа хамгийн гол элементүүд дундаас нэгээр байршуулж болно.

Мессэжний цонхонд байн байн харагддаг, бидний үеийн шинэ авиа дууриах, дүрслэх үгнүүд нь арай хэлний хэм таарахгүй байсан ч хүлээн зөвшөөрөхгүй байж болохгүй. Уулзаагүй байхад харилцаанд авиа дууриах, дүрслэх үгийн илэрхийлэх үр дүн нь эсрэгээрээ илүү их өсөх учраас юм.

Хэвлэсэн газар: БНСУ-ын Эх хэлний академи
Сэтгүүлийн дугаар: 2016он 26-р боть 1дэх дугаар Хавар, Vol.200
Хуудас: 141-149
Орчуулсан: Ч.Дүүрэнжаргал
2017.01.20